



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/022/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Бямбацогт Утас: 261628 Цахим хаяг: byambatsogt.j@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ШУУРХАЙ АРГА
ХЭМЖЭЭ АВАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТОГТОЛЦООНЫ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Н.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2025.02.25 № 07/719
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангаас авах 5.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл болох 1.3 сая ам.долларын санхүүжилтийг Азийн хөгжлийн банкны зөвшөөрлийн дагуу дахин хуваарилж G10-Суурин рентген аппарат 2 ширхэг, G11-Нүүдлийн клиник автомашин 2, ходоодны дуран 2 ширхгийг тус тус худалдан авах гэрээг нэмэлтээр байгуулсан. Уг гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор, төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгах хүсэлтийг Азийн хөгжлийн банканд хүргүүлж, 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Азийн хөгжлийн банкны 565/24 дугаар захидлаар төсөл хэрэгжих хугацааг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсөл хэрэгжүүлэх Зорилт 1-д "Ковид-19 цар тахлын өвчлөл, хүндрэлийн оношилгоо, шинжилгээ болон дархлаажуулалттай холбоотой бараа үйлчилгээгээр хангах" хүрээнд тайлант хугацаанд 8,094,950.9 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийн санхүүжилт гарсан байна. Үүнээс 5,390,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий нүүдлийн клиник-автомашин, Эрүүл мэндийн яаманд 56,950.0 мянган төгрөгийн үнэ бүхий баркод уншигч болон баркод хэвлэгч машины 4 нэр төрлийн тоног төхөөрөмж, Халдварт өвчин судлалын үндэсний төвд 2,648,000.9 мянган төгрөгийн үнэ бүхий G1-RT-PCR багц шинжилгээний машин, хөргөгч, хурилдуур, хилийн боомтуудад тандалтын нэгж байгуулах тоног төхөөрөмжийг 11 аймгийн Зооноз өвчин судлалын төвд тус тус хүлээлгэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төсөл нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,763,963,276.10	4,423,412,495.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,678,697,348.93	4,423,253,995.55
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,678,697,348.93	4,423,253,995.55
3121	Төгрөг	325,644,036.32	271,731,527.27
31211	Төрийн сангийн харилцах	325,644,036.32	271,731,527.27
3122	Гадаад валют	4,353,053,312.61	4,151,522,468.28
31223	Арилжааны банк дахь харилцах	4,353,053,312.61	4,151,522,468.28
34	УРЬДЧИЛГАА	-	158,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	158,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,265,927.17	-
351	Түүхий эд материал	85,265,927.17	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	85,265,927.17	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,925,395.92	8,944,444.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,925,395.92	8,944,444.44
392	Биет хөрөнгө	13,961,110.63	8,944,444.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,650,000.00	12,650,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,622,222.67)	(9,838,888.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,000,000.00	8,000,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,066,666.70)	(1,866,666.67)
393	Биет бус хөрөнгө	3,964,285.29	-
39301	Программ хангамж	9,250,000.00	9,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,285,714.71)	(9,250,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,781,888,672.02	4,432,356,939.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	259,017.43	546,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	259,017.43	546,000.00
4136	Бусад өглөг	259,017.43	546,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	259,017.43	546,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,781,629,654.59	4,431,810,939.99
51	Засгийн газрын хувь оролцоо		
512	Хуримтлагдсан үр дүн	4,781,629,654.59	4,431,810,939.99
51210	Өмнөх үеийн үр дүн	5,731,467,188.76	4,781,629,654.59
51220	Тайлант үеийн үр дүн	(949,837,534.17)	(349,818,714.60)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,781,888,672.02	4,432,356,939.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,703,468,116.65	8,079,213,395.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,703,468,116.65	8,079,213,395.40
120	Нийтлэг татварын бус орлого	96,665,927.17	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,265,927.17	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	85,265,927.17	-
120009	Бусад орлого	11,400,000.00	-
122	Тусламжийн орлого	2,606,802,189.48	8,079,213,395.40
122002	Хандив тусламж /гадаад/	2,606,802,189.48	8,079,213,395.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,427,137,081.97	343,396,590.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,427,137,081.97	343,396,590.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,427,137,081.97	343,396,590.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,116,454.55	199,513,363.64
210101	Үндсэн цалин	190,116,454.55	199,513,363.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,755,802.82	24,614,843.18
210201	Тэтгэврийн даатгал	22,755,802.82	24,614,843.18
2104	Хангамж, бараа материалын зардал	4,940,886.00	14,176,703.00
210401	Бичиг хэрэг	1,658,540.00	10,260,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,097,600.00	175,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	779,746.00	941,703.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,405,000.00	2,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	49,292,480.00
210702	Дотоод албан томилолт	-	49,292,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,718,517.02	44,417,197.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,633,040.02	26,591,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,000,000.00	15,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	2,740,150.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	85,477.00	85,447.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,189,605,421.58	11,382,003.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,544,648.20	2,401,051.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,171,079,821.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,980,952.38	8,980,951.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,276,331,034.68	7,735,816,804.55
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,602,991.45	47,305,690.23
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5,602,991.45	47,305,690.23
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,231,771,560.30	8,132,941,209.38
225003	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	2,231,695,320.00	8,094,950,896.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	76,240.30	37,990,313.38
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4-5)	(2,226,168,568.85)	(8,085,635,519.15)
7	НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(6)	(949,837,534.17)	(349,818,714.60)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,618,202,189.48	126,478,426.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,618,202,189.48	126,478,426.57
120	Нийтлэг татварын бус орлого	11,400,000.00	-
120009	Бусад орлого	11,400,000.00	-
122	Тусламжийн орлого	2,606,802,189.48	126,478,426.57
122002	Хандив тусламж /гадаад/	2,606,802,189.48	126,478,426.57
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,417,049,512.16	334,287,156.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,417,049,512.16	334,287,156.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,417,049,512.16	334,287,156.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,597,436.13	199,225,827.04
210101	Үндсэн цалин	192,597,436.13	199,225,827.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,076,221.83	24,614,843.18
210201	Тэтгэврийн даатгал	22,076,221.83	24,614,843.18
2104	Хангамж, бараа материалын зардал	4,093,286.00	14,335,203.00
210401	Бичиг хэрэг	1,658,540.00	10,418,500.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00	175,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	779,746.00	941,703.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,405,000.00	2,800,000.00
2107	Томилолт, зочны зардал		49,292,480.00
210702	Дотоод албан томилолт		49,292,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,202,747.20	44,417,197.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,202,747.20	26,677,047.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,000,000.00	15,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	2,740,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,171,079,821.00	2,401,605.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,401,605.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,171,079,821.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,201,152,677.32	(207,808,730.23)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,231,695,320.00	56,950,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,231,695,320.00	56,950,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,231,695,320.00	56,950,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,231,695,320.00	56,950,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,231,695,320.00)	(56,950,000.00)
14	Бусад эх үүсвэр	5,602,991.45	47,305,690.23
145004	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5,602,991.45	47,305,690.23
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	76,240.30	37,990,313.38
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	76,240.30	37,990,313.38
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,526,751.15	9,315,376.85
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,025,015,891.53)	(255,443,353.38)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,703,713,240.46	4,678,697,348.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,678,697,348.93	4,423,253,995.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	5,731,467,188.46	5,731,467,188.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	0.30	0.30
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	5,731,467,188.76	5,731,467,188.76
Тайлант үеийн үр дүн	-	(949,837,534.17)	(949,837,534.17)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	4,781,629,654.59	4,781,629,654.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	4,781,629,654.59	4,781,629,654.59
Тайлант үеийн үр дүн	-	(349,818,714.60)	(349,818,714.60)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	4,431,810,939.99	4,431,810,939.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,713,476,300.00	8,341,857,756.40	3,371,618,543.60	71.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,325,000.00	332,172,787.57	4,152,212.43	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,325,000.00	332,172,787.57	4,152,212.43	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,525,000.00	198,967,363.64	557,636.36	99.7
210101	Үндсэн цалин	199,525,000.00	198,967,363.64	557,636.36	99.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,875,000.00	24,614,843.18	260,156.82	99.0
210201	Тэтгэврийн даатгал	24,875,000.00	24,614,843.18	260,156.82	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,725,000.00	14,335,203.00	389,797.00	97.4
210401	Бичиг хэрэг	10,500,000.00	10,418,500.00	81,500.00	99.2
210402	Тээвэр, шатахуун	175,000.00	175,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,250,000.00	941,703.00	308,297.00	75.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,800,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	49,500,000.00	49,292,480.00	207,520.00	99.6
210702	Дотоод албан томилолт	49,500,000.00	49,292,480.00	207,520.00	99.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,100,000.00	44,417,197.75	2,682,802.25	94.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,200,000.00	26,677,047.75	2,522,952.25	91.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,900,000.00	2,740,150.00	159,850.00	94.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	545,700.00	54,300.00	91.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	545,700.00	54,300.00	91.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,377,151,300.00	8,009,684,968.83	3,367,466,331.17	70.4
2200	Дотоод эх үүсвэрээр	11,377,151,300.00	8,009,684,968.83	3,367,466,331.17	70.4
222001	Тоног төхөөрөмж	11,377,151,300.00	8,009,684,968.83	3,367,466,331.17	70.4
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,713,476,300.00	8,079,213,395.40	3,634,262,904.60	69.0
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	11,713,476,300.00	8,079,213,395.40	3,634,262,904.60	69.0
122002	Хандив тусламж /гадаад/	11,713,476,300.00	8,079,213,395.40	3,634,262,904.60	69.0
	Төсвийн тохируулгын дүн		7,201,007.62		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,678,697,348.93		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,423,253,995.55		

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 28,691.5 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ХХОАТ-ын тайланг алдаатай гаргасан	1	28,533.0			1	28,533.0	1	28,533.0				
2025 онд хийгдсэн худалдан авалтыг тайлант хугацааны зардлаар тайлагнасан	1	158.5			1	158.5	1	158.5				
Дүн	2	28,691.5			2	28,691.5	2	28,691.5				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,